



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/582

Зуунмод

Г Газар эзэмших эрхийг баталгаажуулж, 7
газрын хэмжээг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/585 дугаар захирамжаар эзэмшиж буй 1584 м² газраа 600, 727 м²-аар хоёр нэгж талбар болгосныг иргэн Батболд овогтой Сэндэнпүрэв /УЮ69051514/-ын хүсэлтийн дагуу нэгж талбаруудыг нэгтгэн 1327 м²-аар эргүүлэн нэгтгэж, орон сууцны зориулалтаар Номт 1-р баг, Соёл хотхон, Тээвэрчдийн гудамж 310 тоотод 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Б.Сэндэнпүрэвт дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.2. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.3. Холбогдох хууль тогтоомж, хэсэгчилсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/585 дугаар захирамж болон газар эзэмших эрхийн 30720, 753786 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



БАТЖАРГАЛ